

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: САГ-2026/22/НА-СТА-ТТЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитор: Т.Баасанцэнд Утас: 261740 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn Аудитор: Г.Тэлмүүн Утас: 261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	14
3.4.2 Авлага.....	14
3.4.3 Урьдчилгаа.....	15
3.4.4 Бараа материал.....	15
3.4.5 Үндсэн хөрөнгө.....	16
3.4.6 Өр төлбөр.....	17
3.4.7 Засгийн газрын хувь оролцоо.....	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	18
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	21
4.1 Ерөнхий зүйл.....	21
4.2 Материаллаг байдал.....	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	25
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	29

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн, бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30  
Цахим шуудан: info@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ҮНДЭСНИЙ ШИНЖЛЭХ УХААН,  
ТЕХНОЛОГИЙН САНГИЙН АЖЛЫН  
АЛБАНЫ ДАРГА Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

2026.03.25 № 803  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 397.1 сая төгрөгөөр давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа гэрээний хэрэгжилтийг үндэслэж санхүүжилтийг олголгүй, урьдчилгаа төлбөр олгосон 422.0 сая төгрөг;
- Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг төлөвлөөгүй, зарцуулсан 123.0 сая төгрөг;
- Авлагын 33.9 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 31 дүгээр зүйлийн 31.4, 31.4.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дах заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” 2025 оны 121 дүгээр тогтоолоор Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн Ажлын албаны даргын харьяанд Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан, Анагаах ухааны хүрээлэн, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн, Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийг нэгтгэн төсвийн төвлөрүүлэн захирагчийн жагсаалтад нэмсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд эрдэм шинжилгээний ажлын санхүүжилтээс 2025 онд үргэлжлэх суурь судалгааны 24, захиалгат 15, цөм технологийн 1, технологийн туршилт зүгшрүүлэлтийн 8, гадаадтай хамтарсан 68, нийт 116 төсөлд 2,544.8 сая төгрөгийн, 2025 онд шинээр хэрэгжих гадаадтай хамтарсан 4 төсөлд 80.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>14,480,783.6</b>	<b>13,064,343.3</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	434.4	-
33	АВЛАГА	1,781,518.2	1,759,262.2
34	УРЬДЧИЛГАА	10,583,087.2	9,173,843.7
35	БАРАА МАТЕРИАЛ	2,115,743.8	2,131,237.4
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>42,766,047.9</b>	<b>44,068,908.0</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	42,766,047.9	44,068,908.0
39200	Биет хөрөнгө	20,911,571.9	22,217,629.5
39300	Биет бус хөрөнгө	21,854,476.0	21,851,278.5
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>57,246,831.5</b>	<b>57,133,251.3</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>725,508.3</b>	<b>1,008,497.2</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	542,144.8	825,133.7
41300	Өглөг	461,844.8	825,133.7
41400	Урьдчилж орсон орлого	80,300.0	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	183,363.5	183,363.5
42200	Урт хугацаат зээл	183,363.5	183,363.5
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>56,521,323.2</b>	<b>56,124,754.1</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	56,521,323.2	56,124,754.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	31,851,639.3	31,266,435.2
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	585,204.1
51200	Хуримтлагдсан үр дүн	16,388,330.9	15,993,689.8
51210	Өмнөх үеийн үр дүн	12,164,683.3	16,604,533.6
51220	Тайлант үеийн үр дүн	4,223,647.6	(610,843.8)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,281,353.0	8,279,425.0
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>57,246,831.5</b>	<b>57,133,251.3</b>

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>39,136,751.3</b>	<b>32,146,452.9</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,862,449.1	32,146,452.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,274,302.2	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>34,818,022.0</b>	<b>32,749,341.5</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,818,022.0	32,749,341.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,149,051.3	31,610,679.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,971,742.7	17,228,255.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,870,365.2	2,141,915.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	830,519.0	885,457.0
2104	Хангамж, бараа материалын зардал	806,676.6	831,866.4
2105	Нормативт зардал	1,005,009.4	1,057,446.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	554,069.7	481,586.1
2107	Томилолт, зочны зардал	455,156.4	484,902.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,849,624.4	5,583,173.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,805,887.9	2,916,077.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	668,970.7	1,138,661.6
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>4,318,729.3</b>	<b>(602,888.6)</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>95,081.7</b>	<b>7,955.2</b>
<b>VII</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>	<b>(95,081.7)</b>	<b>(7,955.2)</b>

<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>4,223,647.6</b>	<b>(610,843.8)</b>
-----------	---	--------------------	--------------------

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>29,196,893.5</b>	<b>24,956,935.4</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,194.8	<b>24,956,935.4</b>
120	Нийтлэг татварын бус орлого	73,194.8	33,277.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	29,123,698.7	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>28,547,769.4</b>	<b>24,635,251.4</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,547,769.4	24,635,251.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,089,579.2	23,186,315.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,045,397.5	14,238,038.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,510,635.0	1,736,173.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	634,997.0	757,481.5
2104	Хангамж, бараа материалын зардал	557,584.4	536,726.9
2105	Нормативт зардал	559,432.3	588,492.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	524,958.1	562,743.6
2107	Томилолт, зочны зардал	459,765.6	473,799.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,287,300.7	3,788,686.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	509,508.6	504,171.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,458,190.3	1,448,936.4
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>649,124.1</b>	<b>321,684.0</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>648,689.7</b>	<b>322,118.4</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	648,689.7	322,118.4
2200	Дотоод эх үүсвэрээр	648,689.7	322,118.4
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(648,689.7)</b>	<b>(322,118.4)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>434.4</b>	<b>(434.4)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	434.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	434.4	-

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	31,851,639.3	8,449,262.7	12,164,683.3	52,465,585.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	31,851,639.3	8,449,262.7	12,164,683.3	52,465,585.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	31,851,639.3	8,449,262.7	12,164,683.3	52,465,585.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(167,909.7)	-	(167,909.7)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	4,223,647.6	4,223,647.6
10	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>31,851,639.3</b>	<b>8,281,353.0</b>	<b>16,388,330.9</b>	<b>56,521,323.2</b>
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	31,851,639.3	8,281,353.0	16,388,330.9	56,521,323.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	216,202.7	216,202.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	31,851,639.3	8,281,353.0	16,604,533.6	56,737,525.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(1,928.0)	-	(1,928.0)
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(610,843.8)	(610,843.8)
20	<b>2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>31,851,639.3</b>	<b>8,279,425.0</b>	<b>15,993,689.8</b>	<b>56,124,754.1</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>21,636,534,000.00</b>	<b>20,127,481,479.62</b>	<b>1,509,052,520.38</b>	<b>93.0</b>
Татварын бус орлого	21,636,534,000.00	20,127,481,479.62	1,509,052,520.38	93.0
Тусламжийн орлого	21,636,534,000.00	20,127,481,479.62	1,509,052,520.38	93.0
Төсвөөс санхүүжих	21,636,534,000.00	20,127,481,479.62	1,509,052,520.38	93.0
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>21,636,534,000.00</b>	<b>20,127,481,479.62</b>	<b>1,509,052,520.38</b>	<b>93.0</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	21,636,534,000.00	20,127,481,479.62	1,509,052,520.38	93.0
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>21,230,405,000.00</b>	<b>19,782,817,000.82</b>	<b>1,447,587,999.18</b>	<b>93.2</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,376,076,400.00	13,319,470,791.85	56,605,608.15	99.6
Үндсэн цалин	8,300,058,500.00	7,981,868,941.99	318,189,558.01	96.2
Нэмэгдэл	3,308,530,900.00	2,672,906,434.16	635,624,465.84	80.8
Унаа хоолны хөнгөлөлт	929,596,100.00	1,761,487,149.00	(831,891,049.00)	189.5
Урамшуулал	837,890,900.00	903,208,266.70	(65,317,366.70)	107.8

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,650,648,100.00	1,626,137,503.31	24,510,596.69	98.5
Тэтгэврийн даатгал	1,120,121,200.00	1,088,162,476.80	31,958,723.20	97.1
Тэтгэмжийн даатгал	132,169,100.00	131,947,525.59	221,574.41	99.8
ҮОМШӨ-ний даатгал	68,583,300.00	90,679,242.23	(22,095,942.23)	132.2
Ажилгүйдлийн даатгал	65,939,500.00	64,836,177.25	1,103,322.75	98.3
Эрүүл мэндийн даатгал	263,835,000.00	250,512,081.44	13,322,918.56	95.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	846,081,300.00	751,756,205.39	94,325,094.61	88.9
Гэрэл, цахилгаан	277,064,700.00	316,206,580.36	(39,141,880.36)	114.1
Түлш, халаалт	239,697,200.00	147,564,760.23	92,132,439.77	61.6
Цэвэр, бохир ус	61,432,200.00	33,494,944.80	27,937,255.20	54.5
Байрны түрээс	267,887,200.00	254,489,920.00	13,397,280.00	95.0
Хангамж, бараа материалын зардал	119,014,300.00	101,170,636.99	17,843,663.01	85.0
Бичиг хэрэг	19,144,500.00	15,514,723.00	3,629,777.00	81.0
Тээвэр, шатахуун	9,922,000.00	9,922,000.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	50,129,600.00	48,070,051.07	2,059,548.93	95.9
Ном, хэвлэл	3,912,700.00	3,912,700.00	-	100.0
Хог хаягдал зайлуулах, ариутгал	11,267,400.00	4,150,510.00	7,116,890.00	36.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,638,100.00	19,600,652.92	5,037,447.08	79.6
Нормативт зардал	92,079,100.00	77,125,368.40	14,953,731.60	83.8
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70,014,400.00	58,651,968.40	11,362,431.60	83.8
Хоол, хүнс	2,084,600.00	682,300.00	1,402,300.00	32.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,980,100.00	17,791,100.00	2,189,000.00	89.0
Эд хогшил, урсгал засварын зардал	138,991,200.00	110,266,700.00	28,724,500.00	79.3
Багаж, техник, хэрэгсэл	36,291,500.00	21,801,500.00	14,490,000.00	60.1
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	33,292,300.00	21,936,900.00	11,355,400.00	65.9
Урсгал засвар	69,407,400.00	66,528,300.00	2,879,100.00	95.9
Томилолт, зочны зардал	19,646,700.00	19,645,558.00	1,142.00	100.0
Дотоод албан томилолт	19,646,700.00	19,645,558.00	1,142.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,978,838,500.00	3,768,842,617.88	1,209,995,882.12	75.7
Бусад нийтлэг ажил үйлчилгээ	4,916,642,800.00	3,740,273,518.88	1,176,369,281.12	76.1
Аудит, баталгаажуулалт	14,630,100.00	3,583,500.00	11,046,600.00	24.5
Даатгалын үйлчилгээ	2,414,000.00	275,608.00	2,138,392.00	11.4
Тээврийн хэрэгслийн татвар	3,516,700.00	3,085,785.00	430,915.00	87.7
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,345,300.00	-	1,345,300.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,441,400.00	9,205,500.00	7,235,900.00	56.0
Газрын төлбөр	23,663,200.00	12,268,706.00	11,394,494.00	51.8
Улсын мэдээллийн маягт хэвлэх	185,000.00	150,000.00	35,000.00	81.1
Бараа үйлчилгээний бусад зардал	9,029,400.00	8,401,619.00	627,781.00	93.0
Бусад зардал	4,629,400.00	4,001,619.00	627,781.00	86.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,400,000.00	4,400,000.00	-	100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>406,129,000.00</b>	<b>344,664,478.80</b>	<b>61,464,521.20</b>	<b>84.9</b>
Бусад урсгал шилжүүлэг	406,129,000.00	344,664,478.80	61,464,521.20	84.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	-	1,500,000.00	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	398,569,000.00	343,964,478.80	54,604,521.20	86.3

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,060,000.00	700,000.00	5,360,000.00	11.6
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>885</b>	<b>923</b>	<b>(38)</b>	<b>104.3</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>16</b>	<b>7</b>	<b>9</b>	<b>43.8</b>
Төсвийн байгууллага	16	7	9	43.8
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>430</b>	<b>455</b>	<b>(25)</b>	<b>105.8</b>
Удирдах ажилтан	7	7	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	362	389	(27)	107.5
Үйлчлэх ажилтан	61	59	2	96.7
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>430</b>	<b>438</b>	<b>(8)</b>	<b>101.9</b>
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	360	388	(28)	107.8
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	55	63	(8)	114.5
Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	15	-	15	-
<b>НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>(1)</b>	<b>111.1</b>
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	9	10	(1)	111.1

## 2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	-	<b>5,002,097,685.64</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	5,002,097,685.64
122	Тусламжийн орлого	-	5,002,097,685.64
1221	Хандив тусламж /дотоод/	-	5,002,097,685.64
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,002,097,685.64
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,315,670,692.04
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	845,625,170.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,840,801,823.60
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>4,103,064,594.08</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	4,103,064,594.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	4,101,744,594.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	918,568,088.65
210101	Үндсэн цалин	-	736,160,773.65
210102	Нэмэгдэл	-	52,492,614.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	11,865,650.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	118,049,051.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	110,036,154.83
210201	Тэтгэврийн даатгал	-	78,711,729.16
210202	Тэтгэмжийн даатгал	-	7,981,905.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	5,656,057.91
210204	Ажилгүйдлийн даатгал	-	3,695,835.02
210205	Эрүүл мэндийн даатгал	-	13,990,627.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	5,725,240.00
210301	Гэрэл, цахилгаан	-	5,725,240.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	435,556,297.08
210401	Бичиг хэрэг	-	49,539,706.00
210402	Тээвэр, шатахуун	-	297,092,295.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	798,000.00
210404	Ном, хэвлэл	-	34,600,623.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	53,525,673.08
2105	Нормативт зардал	-	542,967,244.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	410,434,345.00
210502	Хоол, хүнс	-	118,273,999.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	14,258,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	675,933,410.55
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	324,686,165.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	36,370,000.00
210604	Урсгал засвар	-	314,877,245.55
2107	Томилолт, зочны зардал	-	454,153,789.00
210701	Гадаад албан томилолт	-	37,940,100.00
210702	Дотоод албан томилолт	-	398,714,289.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	17,499,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	463,034,044.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	461,506,792.55
210803	Даатгалын үйлчилгээ	-	511,340.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	222,712.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	793,000.00

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	495,770,325.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	494,770,325.12
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,320,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,320,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,320,000.00
<b>4</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	-	<b>899,033,091.56</b>
<b>5</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>(899,033,091.56)</b>
<b>6</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	-	<b>(899,033,091.56)</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сангийн үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаа, шинжлэх ухаан, технологийн хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологи болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Шинжлэх ухаан, технологийн санхүүжилт, үр дүнд суурилсан санхүүгийн хяналтын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх түүний үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, санхүүжүүлэх, зарцуулсан хөрөнгийн ашиглалтад хяналт тавих, нэгтгэн тайлагнах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай, бүх талын дэмжлэг үзүүлэхэд үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан нь шударга ёс, ил тод байдлыг эрхэмлэн, олон улсын жишигт нийцсэн ахисан түвшний бүтээлч судалгааг тогтмол санхүүжүүлэх замаар Монгол Улсын тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулна гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д *"төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг* гэж заасны дагуу Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны Б/41 тушаалаар томилогдсон Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны дарга Б.Бат-Эрдэнэ нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Тайлант онд Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 7 хүрээлэн, сангийн санхүүгийн тайланг нэгтгэжээ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны дарга нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Инновацын тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд сангийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" албан даалгавар;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" албан даалгавар;
- Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг шинэчлэн баталсан;

- Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 240 дүгээр тушаалаар “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталсан;

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны бүтцэд дотоод аудитын нэгж байхгүй тул дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус ажлын алба нь Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 10 дүгээр сарын 26-ны өдрийн А/113 дугаар тушаалаар баталсан Эдийн засаг, хөгжлийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглахаар байгаа боловч Сангийн үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байгаа тул Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 113.6 сая төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	434.4	-	(434.4)
Авлага	1,781,518.2	1,759,262.3	(22,255.9)
Урьдчилгаа	10,583,087.2	9,173,843.6	(1,409,243.6)
Бараа материал	2,115,743.8	2,131,237.4	15,493.6
Үндсэн хөрөнгө	42,766,047.9	44,068,908.0	1,302,860.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>57,246,831.5</b>	<b>57,133,251.3</b>	<b>(113,580.2)</b>

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Богино хугацаат өр төлбөр	542,144.8	825,133.7	282,988.8
Урт хугацаат өр төлбөр	183,363.5	183,363.5	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	56,521,323.2	56,124,754.1	(396,569.1)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>57,246,831.5</b>	<b>57,133,251.3</b>	<b>(113,580.2)</b>

Эх сурвалж: Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө арилжааны банканд дахь харилцах дансны 0.4 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлснээр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>434.4</b>	-	<b>(434.4)</b>
<b>Төгрөг</b>	<b>434.4</b>	-	<b>(434.4)</b>
Арилжааны банк дахь харилцах	434.4	-	(434.4)
<b>Дүн</b>	<b>434.4</b>	-	<b>(434.4)</b>

Эх сурвалж: Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

#### Аудитын илрүүлэлт:

- Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн зардлын эдийн засгийн ангилал зөрчиж, гүйлгээ гаргасан 22.4 сая төгрөг;
- Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн худалдан авсан хөрөнгө, материалын дүн бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс зөрүүтэй 18.2 сая төгрөг;
- Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн гэрээ байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн 17.6 сая төгрөг;
- Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн орлого хүлээн авах боломжийг алдсан 13.4 сая төгрөг;
- Ажилчдын цалин хөлс, урамшуулал, хувь хүний орлогын албан татварыг зөрүүтэй олгосон нийт 7.9 сая төгрөг. Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн 5.3 сая төгрөг, Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн 1.8 сая төгрөг, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн 0.8 сая төгрөг;
- Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн томилолтын зардалд унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулж олгосон 0.5 сая төгрөг;

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,759.3 сая төгрөг болж, өмнөх оноос 22.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	447.2	1,170.2	723.0
Төлбөртэй үйлчилгээний авлага	419,507.1	191,026.1	(228,481.0)
Татаас, санхүүжилтийн авлага	850,231.9	453,575.7	(396,656.2)
Татвар, НДШ-ийн авлага	-	146.6	146.6
Байгууллагаас авах авлага	416,612.2	1,021,210.8	604,598.6
Хувь хүмүүсээс авах авлага	94,719.8	92,132.8	(2,587.0)
<b>Дүн</b>	<b>1,781,518.2</b>	<b>1,759,262.2</b>	<b>(22,256.0)</b>

Эх сурвалж: Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Авлага дансны бууралтад төлбөртэй үйлчилгээний авлага 228.5 сая төгрөг, татаас санхүүжилтийн авлага 396.7 сая төгрөгөөр буурснаас голлон шалтгаалсан бөгөөд тайлант хугацаанд 604.6 сая төгрөгийн байгууллагаас авах авлагаар нэмэгдсэн байна. Харьяа хүрээлэнгүүд татаас санхүүжилтийн 453.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг Сангийн яамтай тооцоо нийлж баталгаажуулсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 33.9 сая төгрөг;

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 9,173.8 сая төгрөг болж, өмнөх оноос 1,409.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	10,544,901.6	9,153,077.0	(1,391,824.6)
<b>Урьдчилгаа тооцоо</b>	<b>38,185.6</b>	<b>20,766.6</b>	<b>(17,419.0)</b>
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.9	-	(0.9)
Цалингийн урьдчилгаа	-	2,004.3	2,004.3
Томилолтын урьдчилгаа	38,184.7	18,762.3	(19,422.4)
<b>Дүн</b>	<b>10,583,087.2</b>	<b>9,173,843.6</b>	<b>(1,409,243.6)</b>

Эх сурвалж: Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Урьдчилгаа дансны бууралтад үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн өмнөх онуудад олгосон эрдэм шинжилгээний төсөл, сэдэвт ажлын гүйцэтгэлийг хаасан 4,334.1 сая төгрөг, тайлант онд олгосон 2,980.8 сая төгрөгийн санхүүжилтийг бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэлд үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн төсөл, эрдэм шинжилгээний ажилд урьдчилж олгосон 8,966.1 сая төгрөг, өмнөх оны аудитаар төсөвт төвлөрүүлэхээр акт тогтоосон томилолтын урьдчилгаа 18.8 сая төгрөг, мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2017-2019 онд хэрэгжсэн судалгааны ажлын урьдчилгаа 187.0 сая төгрөг, уламжлалт анагаах ухааны хүрээлэнгийн цалингийн урьдчилгаа 2.0 сая төгрөг тус тус байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 2,131.2 сая төгрөг болж, өмнөх оноос 15.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>347,039.7</b>	<b>305,901.4</b>	<b>(41,138.3)</b>
Тусгай зориулалттай материал	254,024.7	245,517.1	(8,507.6)
Эм боох материал	93,015.0	60,384.3	(32,630.7)
<b>Дуусаагүй үйлдвэрлэл</b>	<b>9,671.2</b>	<b>53.8</b>	<b>(9,617.4)</b>
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	<b>674,662.8</b>	<b>754,768.7</b>	<b>80,105.9</b>
<b>Хангамжийн материал</b>	<b>880,486.8</b>	<b>880,314.5</b>	<b>(172.3)</b>
Бичиг хэргийн материал	209,649.9	42,366.7	(167,283.2)
Аж ахуйн материал	462,757.9	525,771.8	63,013.9

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Сэлбэг хэрэгсэл	9,426.7	9,447.7	21.0
Түлш, шатах тослох материал	6,561.0	3,251.7	(3,309.3)
Барилгын засварын материал	29,100.7	16,484.9	(12,615.9)
Хүнсний материал	3,430.5	1,466.6	(1,963.9)
Бусад хангамжийн материал	159,560.1	281,525.1	121,965.0
<b>Мал амьтад</b>	<b>203,883.3</b>	<b>190,199.0</b>	<b>(13,684.3)</b>
<b>Дүн</b>	<b>2,115,743.8</b>	<b>2,131,237.4</b>	<b>15,493.6</b>

Эх сурвалж: Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Бараа материал дансны үлдэгдэл 15.5 сая төгрөгөөр өссөн нь Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын харьяа хүрээлэнгүүд хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор нийт 3,432.2 сая төгрөгийн бараа материал төсвийн хөрөнгөөр худалдан авч, 10.2 сая төгрөгийн хөрөнгө хандиваар, 688.1 сая төгрөгийн бараа материал шилжүүлэн авч, 3,283.3 сая төгрөгийн бараа материал зарцуулж, 699.1 сая төгрөгийн бараа материал шилжүүлж, 132.5 сая төгрөгийн бараа материал акталсантай холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн аудитын тооллогоор бараа материалын дутагдал илэрсэн 33.9 сая төгрөг;

**3.4.5 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 44,068.9 сая төгрөг болж, өмнөх оноос 1,302.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>20,911,571.9</b>	<b>22,217,629.5</b>	<b>1,306,057.6</b>
Барилга, байгууламж, орон сууц	14,643,520.5	14,255,836.1	(387,684.4)
Авто-тээврийн хэрэгсэл	893,926.7	1,071,733.1	177,806.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	4,581,338.8	6,066,109.4	1,484,770.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	454,003.0	531,309.9	77,306.9
Бусад үндсэн хөрөнгө	285,361.4	246,078.0	(39,283.4)
Ном	53,421.5	46,563.0	(6,858.5)
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>21,854,476.0</b>	<b>21,851,278.5</b>	<b>(3,197.5)</b>
Программ хангамж	12,836.5	10,199.0	(2,637.5)
Бусад биет бус хөрөнгө	21,841,639.5	21,841,079.5	(560.0)
<b>Дүн</b>	<b>42,766,047.9</b>	<b>44,068,908.0</b>	<b>1,302,860.1</b>

Эх сурвалж: Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үндсэн хөрөнгө дансны өсөлтөд Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын харьяа хүрээлэнгүүд төсвийн хөрөнгөөр 430.3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 31.8 сая төгрөгийн хөрөнгө хандиваар, ТӨБЗГ-ын 483 дугаар тогтоолоор 12.0 сая төгрөгийн хөрөнгө балансаас балансад шилжүүлэн авч, нийслэлийн хөрөнгө оруулалтаар 91.2 сая төгрөгийн барилгын ажил үнэ төлбөргүй хийлгэснийг орлогод авч, ТӨБЗГ-ын 433, 734, 735 дугаар тогтоолуудаар үндсэн хөрөнгийг 2,678.3 сая төгрөгөөр үнэ шинэчлэн тогтоож, ашиглалтын хугацааг сунгасан нь нөлөөлсөн байна.

Мөн ТӨБЗГ-ын 750 дугаар тогтоолоор 6.9 сая төгрөгийг үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэн 458, 863 дугаар тогтоолуудаар 344.1 сая төгрөгийн хөрөнгө акталж, данснаас хассан болон тайлант оны элэгдлийн зардал 1,940.8 сая төгрөгөөр буурсан байна.

Биет бус хөрөнгөнд 56.7 сая төгрөгийн таримал ургамлын генетик нөөц бүртгэл, геномын задлан шинжилгээний, үр тарианы үндэс хэмжих, 21.7 сая төгрөгийн мэдээллийн нэгдсэн систем, 13.9 сая төгрөгийн төслийн давхцал шалгах, 13.9 сая төгрөгийн санхүүгийн, 4.5 сая төгрөгийн байгууллагын вэб сайт, апп, 0.6 сая төгрөгийн архив, номын сангийн программууд байна.

Аудитын илрүүлэлт:

- Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүй хөрөнгөнд бүртгэсэн 5.7 сая төгрөг.

### 3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 1,008.5 сая төгрөг болж, өмнөх оноос 283.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>542,144.8</b>	<b>825,133.7</b>	<b>282,988.9</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	261,021.9	302,625.4	41,603.5
Бараа үйлчилгээний зардлын өглөг	120,008.8	189,355.3	69,346.5
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	36,500.0	75,566.0	39,066.0
Байгууллагад төлөх өглөг	10,207.6	238,673.6	228,466.0
Хувь хүмүүст төлөх өглөг	34,106.5	13,662.6	(20,443.9)
Татварын өглөг	-	1,606.9	1,606.9
НДШ-ийн өглөг	-	3,643.9	3,643.9
Урьдчилж олсон орлого	80,300.0	-	(80,300.0)
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>183,363.5</b>	<b>183,363.5</b>	<b>-</b>
ЗГ-ын байгууллага, бусад шатны төсөв	113,331.6	113,331.6	-
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	70,031.9	70,031.9	-
<b>Дүн</b>	<b>725,508.3</b>	<b>1,008,497.2</b>	<b>282,988.9</b>

Эх сурвалж: Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Өр төлбөр дансны өсөлтөд санхүүжилтийн зарцуулах эрх нээгээгүйтэй холбоотойгоор үүссэн байгууллагад төлөх өглөг 228.5 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн урт хугацаат өр төлбөрийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 70.0 сая төгрөг.

### 3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 56,124.8 сая төгрөг болж, өмнөх оноос 396.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Засгийн газрын оруулсан капитал</b>	<b>31,851,639.3</b>	<b>31,266,435.2</b>	<b>(585,204.1)</b>
<b>Өмч /төрийн/ ТӨҮГ</b>	<b>-</b>	<b>585,204.1</b>	<b>585,204.1</b>
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>16,388,330.9</b>	<b>15,993,689.8</b>	<b>(394,641.1)</b>

Өмнөх үеийн үр дүн	12,164,683.3	16,604,533.6	4,439,850.3
Тайлант үеийн үр дүн	4,223,647.6	(610,843.8)	(4,834,491.4)
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>8,281,353.0</b>	<b>8,279,425.0</b>	<b>(1,928.0)</b>
<b>Дүн</b>	<b>56,521,323.2</b>	<b>56,124,754.1</b>	<b>(396,569.1)</b>

Эх сурвалж: Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл хуримтлагдсан үр дүнгийн 394.6 сая төгрөгөөс шалтгаалан буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын харьяа хүрээлэнгүүд 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 81,194.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төсөлд төсөвлөсөн дүнгээс материаллаг өөрчлөлт гарсан зардлын үзүүлэлтийг дурдвал цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд төлөх зардлыг 1,995.7 сая төгрөг, байр ашиглалт, хангамжийн материал, эд хогшил, томилолтын зардлыг 5,350.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамжийн зардлыг 44,995.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 108.9 сая төгрөг, урсгал шилжүүлгийг 24.9 сая төгрөгөөр тус тус бууруулж, нормативт зардлыг 38.5 сая төгрөгөөр нэмж баталсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Төсвийн захирагчийн 2025 оны төсвийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 28,758.1 сая төгрөгөөр тооцон баталсан бөгөөд тайлант оны батлагдсан төсвийг 7,121.6 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Үүнд,

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 408.7 сая төгрөг, хангамжийн материал, нормативт зардал, эд хогшил, томилолтын зардлыг 259.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 6,600.3 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 18.8 сая төгрөгөөр бууруулж, байр ашиглалтын зардлыг 111.2 сая төгрөг, урсгал шилжүүлгийг 54.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 21,636.5 сая төгрөгөөр төлөвлөж, 20,298.1 сая төгрөгийг улсын төсвөөс олгож, 20,127.5 сая төгрөгийг зарцуулж, 170.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Мөн төсвийн байгууллагын өөрийн орлогоос 73,194.8 сая төгрөгийг бүрдүүлж, улсын төсөвт төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 20,127.5 сая төгрөг буюу 93.0 хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардлыг 1,447.6 сая төгрөг, урсгал шилжүүлгийг 61.4 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71805	Шинжлэх ухаан, технологи	21,636,534.0	20,127,481.5	1,509,052.5	93.0
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	16,397,489.4	16,107,520.7	289,968.7	98.2
1.2	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	4,724,810.5	3,567,641.3	1,157,169.2	75.5
1.3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	406,129.0	344,664.5	61,464.5	84.9
1.4	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	39,705.0	39,255.0	450.0	98.9
1.5	81805	Телевизийн хөтөлбөрөөр боловсролын сургалт явуулах	68,400.1	68,400.0	0.1	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Судалгааны үр дүн:** Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ.

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасны дагуу 2025 оны төсвийн тодотголоор харьяа хүрээлэнгүүдийн орон тоо, цалингийн санг бууруулан тодотгосон байна.

Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн жагсаалт, тэдгээрийн харьяалал, орон тооны дээд хязгаарыг баталсан байдаг. Энэ тогтоолд өөрчлөлт ороогүйтэй холбоотой албан хаагчдыг цомхотгох үндэслэлгүй гэсэн шалтгаанаар зарим хүрээлэн орон тоог бууруулалгүй ажилласан байна.

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын харьяа хүрээлэнгүүдийн хоол, унааны зардлыг хөдөлмөрийн дотоод журам, үйлдвэрчний эвлэлийн хамтын гэрээнд тусгасны дагуу ажлын нэг өдөрт олгох дүнг задлан харуулбал:

- Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн 30.0 мянган төгрөг;
- Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан 27.0 мянган төгрөг, анагаах ухааны хүрээлэн 25.0 мянган төгрөг, мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн 20.0 мянган төгрөг;
- Ургамал газар тариалан эрдэм шинжилгээний хүрээлэн 10.0 мянган төгрөг, уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн 6.0 мянган төгрөг.

Гадаад албан томилолтоор шинжлэх ухаан, технологийн үндэсний хорооны гишүүний 14.5 сая төгрөгийн зардал болон эрдэм шинжилгээний хуралд оролцох 2.9 сая төгрөгийн зардлыг үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн эрдэм шинжилгээний ажил арга хэмжээний бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас, ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн нэмэлт санхүүжилтээс 19.9 сая төгрөгийн зардлыг гадаад албан томилолтын зардлаас төслийн сургалтад тус тус зарцуулсан байна.

Гадаад дотоодын сургалтад хамрагдах, төсөл хөтөлбөр, гэрээт ажлыг сурталчлан таниулах сургалтын арга хэмжээнд 100.7 сая төгрөг, олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахад 32.8 сая төгрөг, дотоодын эрдэмтэн судлаачдын чуулга уулзалтад оролцоход 23.0 сая төгрөг, худалдан авах ажиллагааны АЗ-ын сургалтад 1.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд Төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс авсан хандив тусламжаас 1,315.7 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгасан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 845.6 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,840.8 сая төгрөг, нийт 5,002.1 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр, бараа, ажил үйлчилгээний зардалд 4,101.7 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 1.3 сая төгрөгийг зарцуулж, 899.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс 453.7 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэж, Сангийн яамтай тооцоо нийлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны дарга нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд харьцуулалтын аргаар 505.0 сая төгрөг, шууд худалдан авалтын аргаар 264.7 сая төгрөг, нийт 769.7 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулахаар тусгасан байна. Үүнд,

Гүйцэтгэлээр харьцуулалтын аргаар 492.0 сая төгрөгийн 9 худалдан авалт, шууд худалдан авалтын аргаар 143.6 сая төгрөгийн 14 бараа, ажил, нийт 635.6 сая төгрөгийн бараа, үйлчилгээ, хөрөнгийн худалдан авалтыг зохион байгуулсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн тус сангийн ажлын албаны даргын үйл ажиллагааг сайжруулах Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, урсгал зардал, худалдан авах ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Тэлмүүн, аудитор Т.Баасанцэнд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны дарга нь 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дүгээр сарын 05-ны өдрийн 03/132 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 33,133.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 331.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуваарилагдсан төсвийг үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуульд тусгагдсан хэмнэлтийн горим, бусад арга хэмжээг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоход анхаарч ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар нийт 4 зөрчил илэрснээс шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудалд 1 албан шаардлага, худалдан авах ажиллагаатай, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудалд 3 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд харьяа хүрээлэнгүүд шилэн дансанд байршуулах нийт мэдээллээс 367.6 сая төгрөгийн 12 гүйлгээг байршуулаагүй, 5,037.1 сая төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан нь өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, цалингаас бусад таван саяас дээш зарлагын 367.6 сая төгрөгийн 12 гүйлгээг мэдээлээгүй, орлогын 4,716.9 сая төгрөгийн 27 гүйлгээг шилэн дансны цахим системд хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлдэггүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

#### Аудитын илрүүлэлт:

- Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 27 удаагийн 320.2 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

##### 4.4.2.1 Түүврийн байгууллага

Илрүүлэлт 1: Худалдан авах ажиллагааг тендер шалгаруулалтын харьцуулалтын аргаар үнийн санал дуудаж зохион байгуулахдаа хүчингүй болсон тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийг ашигласан, оролцогчид тавигдах ерөнхий шаардлагад хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10-д заасан нөхцөлийг тусгаагүй, 8 тендерт 7.1.10 дахь заалтыг хангаагүй оролцогчдыг сонгон шалгаруулсан бол 1 тендерт тус заалтыг үндэслэн гэрээ байгуулах эрх олгож, давуу байдал үүсгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ", 7.1.10-д "Хүүхэд хамгааллын тухай хуулийн 30.4-т заасан хүүхэд хамгааллын бодлого батлаагүй хуулийн этгээд", Сангийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг тендер шалгаруулалтын харьцуулалтын аргаар үнийн санал дуудаж зохион байгуулахдаа хүчинтэй тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийг ашиглаж байх зөвлөмж өглөө.

**Илрүүлэлт 2:** Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн захирлын 2025 оны тушаалаар томилогдсон худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны зарим гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг гаргуулж аваагүй, баримт бичгийн шаардлагыг хангаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 "Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, тендер хянан үзэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан энэ хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухайгаа, түүнчлэн албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг тус тус мэдэгдэх үүргийг хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг гаргуулан авч байх зөвлөмж өглөө.

**Илрүүлэлт 3:** Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг үндсэн үйл ажиллагааны зардал /80101/-аас гадна эрдэм шинжилгээ судалгааны ажил /80215/ арга хэмжээний бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж /210801/ зардлаас хуваан төлөвлөж, зарцуулж байгаа нь хөтөлбөр, арга хэмжээний зардлын ангиллын бодит гүйцэтгэлийг үнэлэх боломжгүйд хүргэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйл 22.6-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үе шат бүрд төсвийн ангиллыг дараах байдлаар хэрэглэнэ: 22.6.3-т "төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх", 22.6.4-т "төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Сангийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг үндсэн үйл ажиллагааны зардал /80101/-д төлөвлөж, зарцуулж байх зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зарим зүйлс холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитад үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, урсгал зардал, нэмэлт санхүүжилтийн данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар илрүүлсэн 39.7 сая төгрөгийн зөрчлийг шалгаагдагч байгууллагад асуудлын бүртгэлээр танилцуулж, 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг жилийн эцсийн аудитад нэгтгэсэн болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Үндэсний шинжлэх ухаан, технологийн санд зөрчлийг арилгах 25.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 546.3 сая төгрөгийн 8 албан шаардлага, 17.9 сая төгрөгийн 3 зөвлөмж, Анагаах ухааны хүрээлэн 1 албан шаардлага, 424.0 сая төгрөгийн 2 зөвлөмж өгснийг 95.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
<b>Төсвийн шууд захирагч</b>					
Төлбөрийн акт	2	24,999.9	1	6,237.5	25.0
Албан шаардлага	9	546,333.1	9	546,333.1	100.0
Зөвлөмж	5	441,884.8	5	441,884.8	100.0
<b>Нийт дүн</b>	<b>16</b>	<b>1,013,217.8</b>	<b>15</b>	<b>994,455.4</b>	<b>95.0</b>

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

Дээд шатны төсөв захирагчид:

- Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн эрдэм шинжилгээний ажлын санхүүжилтээс Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүргийн ажил, үйлчилгээний зардлыг санхүүжүүлж байгаа асуудал;
- Төсвийн шууд захирагчийн өмнөх оны аудитаар тогтоосон 18.7 сая төгрөгийн актыг төлж барагдуулаагүй асуудал;
- Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж буй санхүүжилтийг Эрүүл мэндийн яамны санхүүгийн тайланд нэгтгээгүй асуудал.

Үндэсний шинжлэх ухаан технологийн сангийн ажлын албаны даргад:

- Шинжлэх ухаан технологийн сангаас санхүүжүүлж буй төсөл, эрдэм шинжилгээний ажлын үр дүн хангалтгүй байгаа талаар холбогдох судалгааны тайлангуудад туссан асуудалд бодлогын менежментийг шинэчлэх шаардлагатай эсэх;
- Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан нь Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолын хавсралтад тусгагдсан эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд суурь судалгааны төсөл болон судалгааны үндсэн чиглэлийн төслүүдэд олгож буй санхүүжилтийг тэргүүлэх чиглэлээр эрэмбэлж олгосон эсэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 1,307.9 сая төгрөгийн 13 алдааг<sup>1</sup> санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан. Үүнд:

- Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн 13.3 сая төгрөг;
- Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн 62.2 сая төгрөг;
- Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн 1,232.4 сая төгрөг.

Аудитаар нийт 728.4 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд, 7.7 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 515.1 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 205.6 сая төгрөгийн зөрчилд 12 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй 728.4 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 397.1 сая төгрөгөөр давсан тул “**Хязгаарлалттай**” дүгнэлт өглөө.

### 5.1 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Илрүүлэлт: Харьяа хүрээлэнгүүдэд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 728.4 сая төгрөгийн 23 зөрчил илэрснээс 7.7 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 515.1 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 205.6 сая төгрөгийн зөрчилд 12 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг, 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, алдаа, зөрчлийг 20.0 хувиар бууруулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өглөө.

### 5.2 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад /Өөрчлөлтгүй/ дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамрагдсан.

### 5.3 Харьяа түүврийн байгууллага

#### 5.3.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Шинжлэх ухаан технологийн сангийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийт 505.0 сая төгрөгийн 9 ажлын тендерт шалгарч гэрээ байгуулсан 9 байгууллагад гэрээний үнийн дүнгийн 80-90 хувийн урьдчилгаа төлбөрийг урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авалгүйгээр олгосон байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т "Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерт шалгарсан байгууллагатай гэрээ байгуулахдаа урьдчилгаа төлбөрийн баталгаа хүлээн авалгүйгээр урьдчилгаа олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

Илрүүлэлт 2: Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн архив болон нууцын өрөөний засварын ижил төстэй ажил, үйлчилгээний төсөвт өртгийг хувааж, нийт 39.7 сая төгрөгийн урсгал засварын ажлыг "Скай ларк" ХХК болон "Ю Юфо" ХХК-тай шууд худалдан авалтын аргаар гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно." 10.5-д "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж, шууд худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

### **5.3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Орлогын төлөвлөлттэй холбоотой**

Илрүүлэлт 1: Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэн нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг төлөвлөхгүйгээр тайлант онд 123.0 сая төгрөгийн орлогыг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4.-т Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана: 31.4.1т "төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо;", 31.4.2-т "төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын тооцоо;" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг төлөвлөж байх.

#### **2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой**

Илрүүлэлт 2: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас урьдчилж олгосон нийт 422.0 сая төгрөгийн санхүүжилтийг байгууллагад өгөх өглөгөөр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн хууль, стандартад заасны дагуу урьдчилгаа төлбөрийн урьдчилж төлсөн зардлын дансанд бүртгэж байх.

**Илрүүлэлт 3:** Шинжлэх ухаан технологийн сангийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 2023-2025 онуудад хэрэгжүүлсэн нийт 313.8 сая төгрөгийн мэдээллийн системүүдийг биет бус хөрөнгөнд бүртгэлгүйгээр шууд зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна:", УСНББОУС 31-т Биет бус хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт: ирээдүйд эдийн засгийн үр өгөөж бий болгох, өртгийг нь найдвартай хэмжих боломжтой байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн хууль, стандартад заасны дагуу мэдээллийн систем хөгжүүлэлттэй холбоотой зардлыг биет бус хөрөнгийн дансанд бүртгэж байх.

## **2. Төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой асуудал**

**Илрүүлэлт 4:** Батлагдсан төсөвт тусгагдаагүй байгууллагын үндсэн чиг үүрэгтэй хамааралгүй ажлыг хэрэгжүүлэхээр Эдийн засаг, хөгжлийн сайдын А/59 тушаалын дагуу нийт 185.4 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгэлээр 149.0 сая төгрөгийг эрдэм шинжилгээ, судалгааны ажил /80215/ арга хэмжээнээс олгосон байна. Үүнд:

- Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэнг үнэлэх, яам, аймаг, нийслэлийн шинжлэх ухаан, технологи, инновацын салбар болон дэд зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, нэгдсэн дүгнэлт тайлан гаргах 35.6 сая төгрөг;
- Шинжлэх ухааны паркийг хөгжүүлэх стратеги менежментийн асуудал 43.2 сая төгрөг;
- Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөгөө, зорилтот хөтөлбөрийг боловсруулах 45.0 сая төгрөг;
- Яам, аймаг, нийслэлийн шинжлэх ухаан, технологи, инновацын салбар болон дэд зөвлөлийг шинжлэх ухаан, технологийн мэдээллээр хангах, хөгжүүлэх чиглэлд хэлэлцүүлэг зохион байгуулах, зөвлөмж гаргах 28.0 сая төгрөг,
- "Гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэх бодлого" олон улсын семинарыг зохион байгуулахаар "Континентал" ХХК-д 19.9 сая төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ: 15.1.1-т "шинжлэх ухаан, технологийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтийг хангуулах";, 15.1.2-т "шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого, тэргүүлэх чиглэлийн төслийг боловсруулах, хэрэгжүүлэх";, 15.1.5-д "үндэсний шинжлэх ухаан, технологийн санг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах, жилийн тайлан, төлөвлөгөөг хэлэлцэх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Өөрийн чиг үүрэгт хамааралгүй ажил, үйлчилгээг батлагдсан төсвөөс санхүүжүүлэхгүй байх.

**Илрүүлэлт 5:** Батлагдсан төсвөөс телевизийн хөтөлбөрөөр боловсролын сургалт явуулах /81805/ арга хэмжээнд зарцуулаагүй боловч Шинжлэх ухааны паркийг хөгжүүлэх стратеги менежментийн асуудал хэлэлцүүлэхэд 43.2 сая төгрөг, Яам, аймаг, нийслэлийн шинжлэх ухаан, технологи, инновацын салбар болон дэд зөвлөлийг шинжлэх ухаан, технологийн мэдээллээр хангах, хөгжүүлэх чиглэлд хэлэлцүүлэг зохион байгуулах, зөвлөмж гаргахад 28.0 сая төгрөг, нийт 71.2 сая төгрөгийн гэрээ байгуулж зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан байна: 31.1.1-т "санхүүжилтийг үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хүрээгээр тодорхойлсон байх;" 32 дугаар зүйлийн 32.2.11-т "төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, тэдгээртэй холбогдсон тайлбар, танилцуулга" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заагдсан шинжлэх ухаан, технологийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах үйл ажиллагааг дэмжих чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>Төсвийн шууд захирагч</b>													
1	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	5	13,301.9	1	3,910.8	4	9,391.1	5	13,301.9	-	-	-	-
2	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	7	62,233.2	1	6,731.8	6	55,501.4	7	62,233.2	-	-	-	-
3	Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн	1	1,232,439.1	-	-	1	1,232,439.1	1	1,232,439.1	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>13</b>	<b>1,307,974.2</b>	<b>2</b>	<b>10,642.6</b>	<b>11</b>	<b>1,297,331.6</b>	<b>13</b>	<b>1,307,974.2</b>	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
<b>Төсвийн төвлөрүүлэн захирагч</b>														
1	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны дарга	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Төсвийн шууд захирагч</b>														
1	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	8	59,046.2	2	5,051.3	3	35,813.0	3	18,181.9	-	-	-	-	-
2	Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн	2	7,505.2	1	1,815.3	-	-	1	5,689.9	-	-	-	-	-
3	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	4	23,340.2	2	807.9	1	17,630.0	1	4,902.3	-	-	-	-	-
4	Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн	2	33,877.5	-	-	-	-	2	33,877.5	-	-	-	-	-
5	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	1	123,035.3	-	-	-	-	1	123,035.3	-	-	-	-	-
6	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан	6	481,550.0	-	-	2	461,650.0	4	19,900.0	-	-	-	-	-
<b>Дүн</b>		<b>23</b>	<b>728,354.4</b>	<b>5</b>	<b>7,674.5</b>	<b>6</b>	<b>515,093.0</b>	<b>12</b>	<b>205,586.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>									
<b>Төсвийн шууд захирагч</b>									
1	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	1	320,211.5	-	-	1	320,211.5	-	-
2	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан	1	367,644.4	-	-	1	367,644.4	-	-
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>687,855.9</b>	-	-	<b>2</b>	<b>687,855.9</b>	-	-
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>									
<b>Төсвийн шууд захирагч</b>									
1	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан	3	-	-	-	-	-	3	-
<b>Дүн</b>		<b>3</b>	<b>-</b>	-	-	-	-	<b>3</b>	-
<b>Нийт дүн</b>		<b>5</b>	<b>687,855.9</b>	-	-	<b>2</b>	<b>687,855.9</b>	<b>3</b>	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1148/А0171238

Улаанбаатар хот

САГ-2026/17/НА-СТА-ЗГТС

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинжлэх ухаан технологийн сангийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийт 505,000,000.00 /Таван зуун таван сая/ төгрөгийн 9 ажлын тендерт шалгарч гэрээ байгуулсан 6 аж ахуй нэгж, 3 төрийн бус байгууллагад гэрээний үнийн дүнгийн 80-90 хувийн урьдчилгаа төлбөрийг урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авалгүйгээр 421,950,000.00 /Дөрвөн зуун хорин нэгэн сая есөн зуун тавин мянган/ төгрөгийн урьдчилгаа олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т "Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Тендерт шалгарсан байгууллагатай гэрээ байгуулахдаа урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авалгүйгээр урьдчилгаа олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны дарга /Б.Бат-Эрдэнэ/, Ерөнхий нягтлан бодогч /Э.Батчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ  
Т.БААСАНЦЭНД  
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1149/А0171238

Улаанбаатар хот

САГ-2026/17/НА-СТА -ЗГТС

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, цалингаас бусад таван саяа дээш 367,644,400.00 /Гурван зуун жаран долоон сая зургаан зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун төгрөг/ төгрөгийн 12 гүйлгээг мэдээлээгүй, орлогын 4,716,909,093.60 /Дөрвөн тэрбум долоон зуун арван зургаан сая есөн зуун есөн мянга ерэн гурван төгрөг жаран мөнгө/ төгрөгийн 27 гүйлгээг шилэн дансны цахим системд хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээллэдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ийг гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол,"; 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлдэггүй, орлогын гүйлгээг хугацаа хоцроож мэдээллэдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны дарга /Б.Бат-Эрдэнэ/, Ерөнхий нягтлан бодогч /Э.Батчимэг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ  
Т.БААСАНЦЭНД  
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1150/А0171238

Улаанбаатар хот

САГ-2026/17/КА-СТА-ЗГТС

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн архив болон нууцын өрөөний засварын ижил төстэй ажил, үйлчилгээний төсөвт өртгийг хувааж, нийт 39,700,000.00 /Гучин есөн сая долоон зуун төгрөгийн урсгал засварын ажлыг "Скай ларк" ХХК болон "Ю Юфо" ХХК-тай шууд худалдан авалтын аргаар гүйцэтгүүлсэн байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно." 10.5-д "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж, шууд худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны дарга /Б.Бат-Эрдэнэ/, Ерөнхий нягтлан бодогч /Э.Батчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ  
Т.БААСАНЦЭНД  
Г.ТЭЛМҮҮН